210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	865.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	412,411.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	360,283.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	52,127.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,800.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,800.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	16,800.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	472.0
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	472.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	51,061.6
2200	Дотоод эх үүсвэрээр	51,061.6

225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	51,061.6
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	508,219.9
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	508,219.9
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	715.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	436,651.5
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	70,853.4
131106	Төсвийн урамшуулал	-
IV	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>(200.0)</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	200.0

### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төсвийн төвлөрүүлэн захирагч сумын Засаг дарга Д.Есболат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/134 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүний нөөц, газар, байгалийн баялаг, дэд бүтцийн давуу талдаа тулгуурласан газар тариалан, үйлдвэр, аялал жуулчлал, нийгмийн үйлчилгээний харилцаа бие биеэ нөхөх зөв зохистой бүтэц бүхий цогц салбаруудыг хөгжүүлж, хүн амын амьдрах таатай орчныг бүрдүүлсэн сум болно” гэж тодорхойлсон байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2021 онд Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй байна.

#### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож,

материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 27093.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 270.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 203.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 451.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 537.2 сая төгрөг болж, 85.7 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө		0.5	0.5	0.6
Банканд байгаа бэлэн мөнгө	451.5	536.7	85.2	99.4
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
<b>Дүн</b>	<b>451.5</b>	<b>537.2</b>	<b>85.7</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 537.2 сая төгрөг байгаагаас сумын Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 162.3 сая төгрөгийн, Өлгий сумын ЗДТГазар 1.8 сая төгрөгийн, Өрхийн ЭМТөвүүд 74.2 сая төгрөгийн, Хот тохижуулах алба 0.6 сая төгрөгийн, ОНХСан 7.3 сая төгрөгийн, СХСангийн дансанд 291.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Аудитын илрүүлэлт:*

*Сумын ТШЗ-ийн тайлангаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчил гараагүй байна.*

#### 3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

#### 3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 1138.4 сая, эцсийн үлдэгдэл 930.8 сая төгрөг болж, 207.6 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	97.7	15.2	-82.5
Төлбөртэй үйлчилгээний авлага		0.2	0.2
Татаас, санхүүжилтийн авлага		42.9	42.9
Зээлийн хүүгийн авлага			-
Бусад авлага	38.7	202.8	164.1
Зээлийн авлага	1002.0	669.7	-332.3
<b>Дүн</b>	<b>1138.4</b>	<b>930.8</b>	<b>-207.6</b>

*Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэл оны эхэнд 1002.0 сая төгрөг байснаас оны эцэст 669.7 сая төгрөг болж буурсан ба нийт авлагын 71.9 хувийг эзэлж байна. Тайлант онд авлагын эргэн төлөлтөөс нэмж зээл олгоогүй байна.

Төсөвт байгууллагуудаас Өрхийн Эрүүл мэндийн төвүүд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 42.9 сая төгрөгийн санхүүжилтийн авлагыг шинээр бүртгэсэн байна.

Хүүхдийн 10 цэцэрлэг, Ерөнхий боловсролын 2 сургууль байгууллагаас авах 180.0 сая төгрөгийн авлагыг шинээр үүсгэсэн байна. Энэ нь аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/1075 дугаартай захирамжаар сургууль, цэцэрлэгүүдийн төсвийн хэмнэлтээс төсөвт хийсэн зохицуулалтаар “Багшийн хөгжлийн танхим” ажиллуулахад зориулж тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авахад гэрээний дагуу шилжүүлж авлага үүсгэсэнтэй холбоотой байна.

ЗДТГазар 1.3 сая төгрөг, ЕБ-ын 1-р сургууль 16.1 сая төгрөгөөр, ЕБ-ын 2-р сургууль 0.5 сая төгрөгөөр авлагаа бууруулсан байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай авлага байхгүй байна.

*Аудитын илрүүлэлт:*

*Сумын ТШЗ-ийн тайлангаар авлагатай холбоотой алдаа зөрчил гараагүй байна.*

### 3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

### 3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

### 3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 959.1 сая, эцсийн үлдэгдэл 1,100.4 сая төгрөг болж, 141.3 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	106.4	122.1	15.7
Хангамжийн материал	852.7	978.3	125.6
<b>Дүн</b>	<b>959.1</b>	<b>1100.4</b>	<b>141.3</b>

*Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсөвт байгууллагууд төсвийн хөрөнгөөр 1446.4 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 169.8 сая төгрөгийн материал үнэгүй хүлээн авч данс бүртгэлд тусгаж, үйл ажиллагаандаа 1474.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Өрхийн ЭМТ-үүдийн материалын үлдэгдэл Ковид-19 цар тахалтай холбоотойгоор худалдан авсан, үнэгүй хүлээн авсан материалын үлдэгдэл нэмэгдсэнээс, зарим сургууль, цэцэрлэгийн бараа материалын үлдэгдэл үнэгүй авсан, худалдан авсан материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотойгоор өссөн байна.

*Аудитын илрүүлэлт:*

*ЗДТГазар 10.7 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийн тооллого хийж баталгаажуулаагүй, тайлант онд зарцуулсан 20.1 сая төгрөгийн шатахууны нярвын бараа материалын тайланг гаргаагүй, шатахууны орлого, зардлыг 3.2 сая төгрөгөөр дутуу гаргасан, шатахууны зарцуулалтын тооцоо хийгдээгүй байна.*

Хүүхдийн 5 дугаар цэцэрлэг нь цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар хүнсний материалын данснаас 2.9 сая төгрөгийн төгрөгийн чанар байдлаа алдсан материалыг мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн акт, дүгнэлт гаргуулаагүй, акталж данснаас хассан, устгалтын акт үйлдэж баримтжуулаагүй, өмнөх оны аудитаар хүнсний материалыг чанар байдлаа алдаж муудахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүүхдийн 15 дугаар цэцэрлэг няравын хүнсний материалын тайлан болон санхүүгийн тайлангийн бараа материалын тодруулга тайланд хүнсний материалын зарлагын дүнг 3.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 42,197.9 сая, эцсийн үлдэгдэл 59,250.4 сая төгрөг болж, 17,052.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	36218.9	53066.7	16847.8
Биет бус хөрөнгө	5979.0	6183.7	204.7
<b>Дүн</b>	<b>42197.9</b>	<b>59250.4</b>	<b>17052.5</b>

Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 238.5 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 18275.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 429.2 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасаж, 50.5 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна. Үндсэн хөрөнгөд нийт 1389.2 сая төгрөг элэгдэл байгуулжээ.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГазар жилийн эцсийн тооллогыг зохих журмаар хийж үлдэгдэлийг баталгаажуулаагүйгээс үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлийн дүн, санхүүгийн тайлан дахь дүнгээс 22.4 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 222.7 сая, эцсийн үлдэгдэл 482.3 сая төгрөг болж, 259.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	9.4	42.4	33.0	12.7
Бараа үйлчилгээний зардлын өглөг	42.0	38.7	-3.3	-1.2
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	1.5	39.0	37.5	14.4
Байгууллагад төлөх өглөг	162.4	362.2	199.8	77.0
Хувь хүмүүст төлөх өглөг	7.4	-	-7.4	-2.9
<b>Нийт дүн</b>	<b>222.7</b>	<b>482.3</b>	<b>259.6</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн жилийн эцсийн үлдэгдлийн 199.8 сая төгрөг нь байгууллагад төлөх өглөг, татаас санхүүжилтийн өглөг 37.5 сая төгрөг, 33.0 сая төгрөг нь ажилчидтай холбоотой өглөг байна.

Өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага холбоотой 53.7 сая төгрөгийн өглөг нэмэгдэж, ЗДТГ 5.6 сая төгрөгийн, ИТХ 6.3 сая төгрөгийн, Хот тохижилтын алба 24.7 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэгүүд 4.0 сая төгрөгийн, Ерөнхий боловсролын сургуулиуд 386.5 сая төгрөгийн, Төрийн сан 1.5 сая төгрөгийн он дамжсан төсөл арга хэмжээний дутуу олгосон санхүүжилттэй холбоотой өглөгтэй гарсан байна.

Ерөнхий боловсролын 1, 2, 3, 4 дүгээр сургуулиудын халаалтын өр 259.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь халаалтын зардлын төсвийг сургуулийн төсөвт дутуу суулгасан, төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал байна.

**Аудитын илрүүлэлт:**

*ЗДТГазар 5.6 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг үүсгэж, шатахууны 0.2 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан байна.*

*ИТХурал Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.2-т заасныг зөрчиж шинээр нэг орон тоо авч ажиллуулсанаас шалтгаалан 6.3 сая төгрөгийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэсэн байна.*

*Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль “Эрчим” ХХК-ны 2021 оны жилийн эцсийн тооцоо нийлсэн актаар он дамжсан 31.0 сая төгрөгийн, тайлант оны тооцооны зөрүү 36.1 сая төгрөгийн бүгд 67.1 сая төгрөгийн өглөгийг хүлээн зөвшөөрч баталгаажуулаагүй байна.*

**3.5.9 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 44524.2 сая, эцсийн үлдэгдэл 61336.7 сая төгрөг болж, 16812.5 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №6 Засгийн хувь оролцоо /сая төгрөг/*

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт/+, бууралт -/</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14767.3	14965.6	198.3	1.1
Хуримтлагдсан үр дүн	17541.7	34164.2	16622.5	98.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	12215.2	12206.9	-8.3	0.0
<b><u>Дүн</u></b>	<b>44524.2</b>	<b>61336.7</b>	<b>16812.5</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний дансанд 8.3 сая төгрөгөөр өөрчлөлт орсон. Хуримтлагдсан үр дүн 34164.2 сая төгрөг болж 16812.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

**3.5.10. Орлогын данс**

Өлгий сум нь 2021 онд гүйцэтгэлээр орон нутгийн орлогоос 1748.5 сая төгрөгийн орлого оруулж, тусламж санхүүжилтийн орлогоор тусгай зориулалтын шилжүүлгээс 24353.3 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 1199.9 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 1067.7 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 508.2 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 18.1 сая төгрөг оруулан, үнэ төлбөргүйгээр 18052.8 сая төгрөгийн хөрөнгө, 169.6 сая төгрөгийн бараа материалыг хүлээн авч, нийтдээ 47118.1 сая төгрөгийн орлого бүрдүүлэн ажилласан байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт орлого 47118.2 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 10963.1 сая төгрөгөөр буюу 30.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орон нутгийн орлого, төсвийн урсгал, төсөвт байгууллагын өөрийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материалын орлого байна.

### 3.5.11 Зардлын данс

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт зардал 30035.9 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 198.2 сая төгрөгөөр буюу 0.7 хувиар өссөн байна.

Нийт зардлын 93.5 хувь нь бараа үйлчилгээний зардал, 6.5 хувь нь урсгал шилжүүлэг байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хангамж, бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлууд 3.0-1340.6 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

#### *Аудитын илрүүлэлт:*

*Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үзэхэд Засаг даргын тамгын газар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардлыг батлагдсан төсвийн 10 хувиар буюу 22.3 сая төгрөгийн урсгал зардлын хэмнэлт гаргахаар тооцож төсөвт төвлөрүүлээгүй, тогтоолын 1.4-т заасныг зөрчиж 2.2 сая төгрөгийн албаны конторын тавилга худалдан авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй.*

Иргэдийн төлөөлөгчдийн хурал үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн 10 хувиар буюу 1.2 сая төгрөгийн урсгал зардлын хэмнэлт гаргахаар тооцож төсөвт төвлөрүүлээгүй, тогтоолын 1.2-т заасныг зөрчиж шинээр нэг орон тоо авч ажиллуулсан, тогтоолын 1.4-т заасныг зөрчиж 0.6 сая төгрөгийн албан конторын тавилга худалдан авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй.

Ерөнхий боловсролын 6, 7, 10 дугаар сургуулиуд тогтоолын 1.1-д заасныг хэрэгжүүлээгүй 7.5 сая төгрөгийн, Хүүхдийн 1, 4, 6, 8, 9, 13 дугаар цэцэрлэгүүд тогтоолын 1.1, 1.4-т заасныг хэрэгжүүлээгүй 12.3 сая төгрөгийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

Мөн Хүүхдийн 1, 6, 8 дугаар цэцэрлэгүүд тогтоолын 1.2-т заасныг хэрэгжүүлээгүй 68.1 сая төгрөгийн зардал гаргасан байна.

*ЕБ-ын 5 дугаар сургууль норматив зардлаас 1.4 сая төгрөгийн бараа материалыг орлогод аваагүй, шууд зардлаар бүртгэж тайлагнасан.*

*Хотгор Эрүүл мэндийн төв ажилчдад олгосон тэтгэмжийн 16.8 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.*

*Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль үдийн цайны 41.8 сая төгрөгийн, бусад зардлын 4.6 сая төгрөгийн нийт 46.5 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.*

*Хүүхдийн 13 дугаар цэцэрлэг 245.2 сая төгрөгийн бараа үйлчилгээний зардлын гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан, хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийн журналуудыг бүрэн хөтлөөгүй байна.*

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тайлант онд Өлгий сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 27782.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 27424.9 сая төгрөгийг урсгал зардалд, 357.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 24357.0 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 2650.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 334.3 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 441.2 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

#### Төсвийн гүйцэтгэл

Өлгий сум нь 2021 онд гүйцэтгэлээр нийтдээ 27721.5 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого бүрдүүлснээс тусгай зориулалтын шилжүүлгээс 24254.5 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 2847.6 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 334.3 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 285.4 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 285.0 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон орлого бөгөөд үндсэн үйл ажиллагааны орлого 85.0 сая төгрөгөөр тасарсан үзүүлэлттэй байна.

Нийт санхүүжилтээс 99.3 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 27473.4 сая төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлого, мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй холбоотой байна.

#### Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Аймгийн ИТХ-ын 2020 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 11 дугаар тогтоолоор Өлгий сумын 2021 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 1604.1 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны “2021 оны төсөвт тодотгол хийх тухай” 2021 оны 41 дүгээр тодотголоор 1604.1 сая төгрөгөөр хэвээрээ баталсан байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 22 дугаар хуралдааны тогтоолоор 2021 орлогын төлөвлөгөөг 1604.1 сая төгрөгөөр хэвээр нь баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 1748.5 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 144.4 сая төгрөгөөр буюу 109.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

<i>Хүснэгт №7 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл</i>				<i>/сая төгрөг/</i>	
<u>Үзүүлэлт</u>	<u>Төлөвлөгөө</u>	<u>Гүйцэтгэл</u>	<u>Өсөлт/+/ бууралт /-/</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>	
I.Татварын орлого	1579.7	1658.6	78.9	94.8	
II.Татварын бус орлого	24.4	89.9	65.5	5.2	
<b>Нийт дүн</b>	<b>1604.1</b>	<b>1748.5</b>	<b>144.4</b>	<b>100.0</b>	

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд хувь хүний орлогын албан татвар 108.2 сая төгрөгөөр, өмчийн татвар 0.4 сая төгрөгөөр, татварын бус орлого 65.5 сая төгрөгөөр давж биелэгдэн, бусад татвар 30.5 сая төгрөгөөр тасарсан байна.

Хөрөнгө борлуулсны орлогын татвар 121.5 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлого 65.5 сая төгрөгөөр, бусад орлого 84.3 сая төгрөгөөр давж биелэгдсэн нь орлогын төлөвлөгөө давж биелэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар буюу хөрөнгийн орлого 73.7 сая төгрөгөөр, газрын төлбөр 31.1 сая төгрөгөөр, орлогыг нь тодорхойлох боломжгүй иргэдийн орлогын тавар 23.9 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хураамж 2.4 сая төгрөгөөр, хог хаягдлын хураамж 1.8 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 396.0 сая төгрөгийн, оны эцэст 162.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт №8 Төсвийн байгууллагуудын 2021 оны төсвийн зарлагын гүйцэтгэл:

*/сая төгрөг/*

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	ИТХурал	172.2	172.2	-
2	ЗДТГазар	867.2	867.2	-
3	Ерөнхий боловсролын сургуулиуд	15,269.2	15,227.9	-41.3
4	Хүүхдийн цэцэрлэгүүд	8,148.1	8,092.7	-55.4
5	Өрхийн ЭМТөв	1,021.1	1,021.1	-
6	Хотгор Эмнэлэг	205.7	205.7	-
7	ХТАлба	219.4	219.4	-
8	ОНХСан	357.9	350.6	-7.3
9	СХСан	200.0	0.7	-199.3
10	Хувийн сургуулиуд	968.6	962.4	-6.2
11	Хувийн цэцэрлэгүүд	353.4	353.4	-
	<b>Нийт дүн</b>	<b>27,782.8</b>	<b>27,473.3</b>	<b>-309.5</b>

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсөвт байгууллагууд тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас нийтдээ 508.2 сая нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна.

Үүнээс цалин хөлстэй холбоотой зардалд 1.6 сая, гэрэл цахилгаан 1.9 сая, бичиг хэрэг 8.5 сая, тээвэр шатахуун 3.2 сая төгрөг, шуудан холбоо 0.6 сая, хог хаягдал зайлуулах 2.2 сая, бага үнэтэй, түргэн элэгдэх зүйл 3.6 сая төгрөг, норматив зардалд 0.7 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 3.8 сая, томилолт, зочны зардал 0.5 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 0.9 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 412.4 сая, урсгал шилжүүлэгт 17.3 сая, хөрөнгийн зардал 51.0 сая нийт 508.2 сая төгрөгийг зарцуулж, мөнгөн үлдэгдэлд 0.2 сая төгрөг үлдсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого ороогүй байна.

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Өлгий сумын Засаг дарга нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2021 онд 79 мэдээллийг ил тод байршуулахаас 32 мэдээллийг хугацаандаа байршуулж, 45 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, шилэн дансны мэдээлсэн байдлын дундаж 40.5 хувьтай, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн багцад хамаарах 43 байгууллагыг хамруулан, мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

#### *Аудитын илрүүлэлт:*

*Засаг даргын тамгын газар шилэн дансанд 45 мэдээллийг хугацаа хоцроож байршуулан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.*

*Иргэдийн төлөөлөгчдийн хурал шилэн дансны 46 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.*

*Хотгор Эрүүл мэндийн төв шилэн дансанд 2.0 сая төгрөгийн авлага үүссэн мэдээллийг оруулаагүй, мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж хувь 90 хувьтай байна.*

*Хүүхдийн 20 дугаар цэцэрлэг шилэн дансанд 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 225.6 сая төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй.*

*ЕБ-ын 5 дугаар сургууль шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5, 6.4.8-д заасан 85.0 сая төгрөгийн 5 мэдээллийг байршуулаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.*

*ЕБ-ын 6 дугаар сургууль шилэн дансанд 49 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж хувь 66 хувьтай байна.*

*ЕБ-ын 8 дугаар сургууль шилэн дансанд 27 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж хувь 81 хувьтай байна.*

*ЕБ-ын 10 дугаар сургууль шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.4.4, 6.4.6, 6.4.8 -д заасан 518.7 сая төгрөгийн 19 мэдээллийг байршуулаагүй, өмнөх оны санхүүгийн*

тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн шилэн дансанд 312.7 сая төгрөгийн 32 гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроож, 37.9 сая төгрөгийн 12 гүйлгээний мэдээллийг байршуулаагүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 72.7 хувьтай байна.

Сум хөгжүүлэх сан шилэн дансанд 285.0 сая төгрөгийн орлогын мэдээлэл, жилийн эцсийн 669.7 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдлийн талаарх мэдээллийг байршуулаагүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт тэг хувьтай байна.

Бусад төсөвт байгууллагуудын тайлангаар шилэн данстай холбоотой зөрчил дутагдал гараагүй байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид шилэн данстай холбоотой 3 зөвлөмж өгөгдсөн ба зөвлөмжийн биелэлтийг Өлгий сумын Засаг даргын 2021.11.07-ны 2/490 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Зөвлөмжийн биелэлтийг давтан шалгаж үзэхэд 50 хувьтай хэрэгжсэн байна.

*Хүснэгт: №8* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	3		3				50%
<b>Нийт</b>	<b>3</b>		<b>3</b>				<b>50%</b>

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 40 төсвийн байгууллага, 3 тусгайн сан нийт 43 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 13 байгууллагад дүгнэлт гаргаж, 30 байгууллага, нэгжийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Өлгий сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт, бусад 12 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Сумын ИТХ, Хүүхдийн 22 цэцэрлэг, Хот тохижуулах алба, Хувийн сургууль, цэцэрлэгүүд, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа зөрчил гараагүй байна.

#### **Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга**

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой залруулга гараагүй байна.

#### **Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага:**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлантай холбоотой алдаа зөрчил илрээгүй, зөвлөмж өгөгдөөгүй.

1.Аудитаар шилэн данстай холбоотой нэг зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв. Үүнд:

1.Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2021 онд 79 мэдээллийг ил тод байршуулахаас 32 мэдээллийг хугацаандаа байршуулж, 45 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, шилэн дансны мэдээлсэн байдлын дундаж 40.5 хувьтай, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4-т “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх”, 5.1.4-т “мэдээллийг тогтмол шинэчилж байх”, 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-т “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 7.1-д “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын холбогдох заалтуудыг мөрдөж ажиллах, сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллүүдийг хугацаанд нь бүрэн оруулах, зөрчлийг арилгаж, дахин давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2749.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнээс

Өлгий сумын ЗДТГ-т 2.1 сая төгрөгийн зөрчилд акт тогтоосон.

Өлгий сумын ЗДТГ-т 86.8 сая төгрөгийн, ИТХ-д 11.4 сая төгрөгийн, Ерөнхий боловсролын сургуулиудад 621.5 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэгүүдэд 558.5 сая төгрөгийн, СХСанд 954.7 сая төгрөг, ОНХСанд 350.6 сая төгрөгийн зөрчилд тус тус зөрчил арилгуулах албан шаардлага өгөгдсөн байна.

Мөн Ерөнхий боловсролын сургуулиудад 149.0 сая төгрөгийн зөрчилд 4, Хотгор хүн эмнэлэгт 18.8 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж тус тус хүргүүлээ.

Хүснэгт 8: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ИТХурал	1	11.4					1	11.4		
2	Засаг даргын тамгын газар	4	91.2			2	2.1	2	89.1		
3	Ерөнхий боловсролын сургуулиуд	15	738.4			2	1.2	9	621.7	4	115.7
4	Хүүхдийн цэцэрлэгүүд	17	558.5	7	25.5			10	558.5		
5	Хотгор Хүн эмнэлэг	2	18.8							2	18.8
6	ОНХСан	1	350.6					1	350.6		
	СХСан	1	954.7					1	954.7		
<b>Нийт дүн</b>		<b>41</b>	<b>2749.3</b>	<b>7</b>	<b>25.5</b>	<b>4</b>	<b>3.3</b>	<b>24</b>	<b>2586.2</b>	<b>6</b>	<b>134.5</b>

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

### 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидлаар зөвлөмж өгөх асуудал гараагүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

/сая төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өлгий сумын ТТЗ СНТайлан	1						1			